

ЭРДЭНЭЦАГААН СУМ

2023 ОНЫ 08 ДУГААР САРЫН МЭДЭЭ

Хууль, эрх зүй, удирдлага зохион байгуулалтын хүрээнд:

Сумын Засаг даргын захирамж 12, Албан тоот 9 гаргаж ажилласан. Төсөвт байгууллагуудаас өргөдөл гомдлын мэдээг авч нэгтгэсэн. Сүхбаатар аймгийн Төрийн архивт тушаах 2013-2018 оны баримтанд нягтлан шалгалт хийх бэлтгэл ажлыг эхлүүлээд байна.

Ерөнхий боловсролын чиглэлээр:

2023-2024 оны хичээлийн жилд нэгдүгээр ангид элсэх сурагчдын бүртгэлийг хийх элсэлтийн 2 баг бүрэлдэхүүнтэй байгуулж, бүртгэлийг E-mongolia системээр цахимаар зохион байгуулж байна.

Монголын физикийн багш нарын үндэсний сургалт зөвлөгөөнд физикийн багш нар оролцон, боловсролын салбарын шинэчлэл, заах арга зүй, физикийн хичээлийн онцлог, давуу тал, дэлхийн бусад орны туршлага гэх мэт олон сэдвийн хүрээнд ярилцаж, мэдлэгээ хуваалцаж байна

23-53 насны 44 багш ажилчид Сүхбаатар аймгийн нэгдсэн эмнэлэгт урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан.

“Орон нутгийн өсвөр үеийнхэнд хувь хүний ур чадвар, энтрепренершипийн боловсрол олгох” төслийн хүрээнд ESEL хөтөлбөрт хамрагдаж, бичил төсөл хэрэгжүүлж байгаа суралцагчдын “ТУРШЛАГА СОЛИЛЦОХ ҮНДЭСНИЙ УУЛЗАЛТ”-нд Б.Мөнхжин, С.Хонгорзул нар оролцлоо.

Боловсролын ерөнхий газар, “TEACH FOR MONGOLIA” НҮТББ болон “Google Education” байгууллагатай хамтын ажиллагааны хүрээнд Монгол улсад Google Certified Trainer бэлтгэх хөтөлбөрт багш Оюунтуяа хамрагдсан.

Соёлын чиглэлээр.

Егүзэр хутагтын музей, Хатагины хар сүлдний тахилгын өргөөгөөр ОХУ-ын Хатагинчууд зочилсон. “НҮҮДЭЛЧИН МОНГОЛ-2023” олон улсын фестивальд сум орон нутгаа төлөөлөн соёлын өв тээгч МУСТА А.Оюунгэрэл үзэмчин ардын дуугаар оролцсон. Мөн энэхүү фестивалд үзэмчин “Жилийн цай” брэнд бүтээгдэхүүнээ сурталчилсан.

Номын сангийн явуулын үйлчилгээг хөдөөгийн 4 багт 184 иргэнд хүргэж ажилласан.

Мал эмнэлэгийн тасаг:

Аймгийн Засаг даргын 2023 оны 08-р сарын 09-ны өдрийн А/129 тоот “Хонины Цэцэг” өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалт хийх тухай захирамжын дагуу сумын Засаг даргын 2023 оны 08-р сарын 10-ны өдрийн А/186 тоот захирамжийн дагуу 715 өрхийн 72202 хурга төлөвлөөд байна. Аймгийн Мал эмнэлгийн газраас 72,200 литр вакциныг татан авчирсан. Энэхүү ажилд 6 ажлын хэсэг гарч 6 эмч, 10 туслах ажилтан, санитарч- 2, Нийт-24 ажиллаж байна. Мөн аймгийн Мал эмнэлгийн газраас орон нутгийн вакцин болох Цусан халдварт, Дотрын халдварт хордлого, Дуут, Галзуу, гэх вакцинуудыг авчирж тарааж өгөөд байна. Аймгийн Засаг даргын 2023 оны 08-р сарын 15-ны өдрийн А/495 тоот Бруцеллёзын дархлаажуулалт хийх тухай захирамж гарсны дагуу аймгийн Мал эмнэлгээс вакцинжуулалтыг арайхан татаагүй байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр:

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих ажлын хүрээнд 3 иргэнийг ажлын байрны бүртгэлд бүртгэсэн. Хүүхдийн мөнгөн тэтгэмжтэй холбогдолтой асуудлаар хандсан 9 иргэнд мэдээлэлийг тухай бүр нь хүргэж, шинээр төрсөн 19 хүүхдийг бүртгэн хүүхдийн мөнгөн тэтгэмжид хамруулж ажилласан. МУ-ын Засгийн газрын 340 дүгээр тогтоолын хэрэгжилтийг ханган цалинтай ээж хөтөлбөрт 15 ээжийг хамруулсан. Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээ үзүүлдэг дэлгүүрүүдэд ХАББ-ийн жагсаалтыг өгч хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагдсан 12 өрхийн тайланг хүргүүлсэн.

Малчдын мал сүргийн сайжруулах, нэг малаас авах ашиг шимийг нэмэгдүүлэх зорилгоор аймгийн ХААГ-тай хамтран Сэлэнгэ аймгийн Хушаат сумаас махны чиглэлийн Хар ангус 2, сүү махны чиглэлийн Сименталь үүлорийн 3 бухыг 3,5,7-р багийн өрхүүдэд үхэр солилцоогоор өгсөн.

Тайлан бичсэн: ХЭЗ,ХШҮ- хариуцсан мэргэжилтэн Д.Жагварал.